

**Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумын нутагт  
аргаль хонины хурга барьж радио долгион бүхий хүзүүвч зүүсэн  
тухай тайлан**

2007-04-28



Боловсруулсан: Г.Цогтжаргал, Аргаль төвийн ажилтан, судлаач,  
О.Мөнхтогтох, Дэлхийн байгаль хамгаалах сан  
Хянасан: Ё.Онон, Дэлхийн байгаль хамгаалах сан

Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар нь Увс аймаг дахь ОХУ-тай хиллэдэг хил орчмын аргаль хонины шилжилт хөдөлгөөн, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, хамгааллыг сайжруулах зорилгоор Сагил, Бөхмөрөн сумдын нутагт аргаль хонины нүүдэл шилжилт, тоо толгойг радио дохиололын аргаар тодорхойлох судалгааны цэгийг Бөхмөрөн сумын Мандахын аараг хэмээх газар 2005 оны IV сараас эхлэн байгуулж судалгааны ажлыг өнөөг хүртэл тасралтгүй явуулж байна.

### **Зорилго**

Увс аймгийн Бөхмөрөн сумын Мандахын аараг, Сагил сумын Цагаан гол зэрэг газарт аргаль хонины хурга барьж дохиололтой хүзүүвч зүүх.

### **Судалгааны материал, арга зүй**

Барьсан хургыг бүртгэх, хэмжилт авах тусгайлан боловсруулсан маягт, тэмдэглэлийн дэвтэр, зургийн аппарат, компас, Garmin Venture маркийн байршил тодорхойлогч “GPS”, зөөлөн болон төмөр метр, жин, термометр (халууны шил), дуран, телескоп, богино болон хэт богино долгионы радио станц зэрэг багж хэрэгсэл ашигласан болно.

Туруутныг барих олон арга байдаг боловч бид төрөөд удаагүй нялх хурганы эхийг нь цочооход хургаа нуудаг зан үйлийг ашиглаж, хярж нуугдсан хургыг сэм гэтэн барих арга хэрэглсэн болно. Хургыг барьхад 2-3 хүн байх бөгөөд барьж авсан даруйдаа тусгайлан бэлтгэсэн малгайгаар хурганы нүдийг таглаж хэмжилт болон бусанд мэдээг 10-15 минутын хооронд багтаан авсан байх шаардлагатай. Барьсан хурганд дохиолол бүхий 2900 E 23 rd Ave маркийн 130 гр жинтэй, сунамтгай резинэн хүзүүвч зүүлээ. Дохиолол бүхий хүзүүвчнээс илгээсэн дохиололыг 426 WEST TAFT AVENUE MODEL R 1000 маркийн хүлээн авагч, гар антенн ашиглан тухайн хүзүүвчтэй амьтны байршилыг тогтоож байсан ба цаашид энэ аргаар тогтмол хяналт тавих юм. Барьсан бүх хурганд биеийн хэмжилт хийж, холбогдох бусад мэдээллийг тэмдэглэн авсан болно.

### **ХУРГА БАРЬСАН МЭДЭЭНИЙ ХУУДАС**

Барьсан газрын нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_ Зүйл: \_\_\_\_\_ Барьсан: \_\_\_\_\_

Барьсан цаг: \_\_\_\_\_ Тавьсан цаг: \_\_\_\_\_ Барьсан нийт хугацаа: \_\_\_\_\_

Хүйс: \_\_\_\_\_ Нас: \_\_\_\_\_ Биеийн жин: \_\_\_\_\_ (кг/лб)

Хурганы нэр: \_\_\_\_\_ Хүзүүвчний дугаар: \_\_\_\_\_

Байршил (GPS): \_\_\_\_\_ Өндөр: \_\_\_\_\_

### **Биеийн хэмжилт (см)**

Чих: \_\_\_\_\_ Сүүл: \_\_\_\_\_ Урд шилбэний урт: \_\_\_\_\_ Хойд шилбэний урт: \_\_\_\_\_

Сэрвээний Өндөр: \_\_\_\_\_ Цээжний тойрог: \_\_\_\_\_ Биеийн нийт урт: \_\_\_\_\_

Хүзүүний тойрог: \_\_\_\_\_ Турууны урт/Өргөн: \_\_\_\_\_

**Биеийн температур, зүрхний цохилт, амьсгалын тоо**

Цаг	Температура	Зүрхний цохилт	Амьсгалын тоо

**Орчны цаг агаарын байдал (°C/°F)**

Цаг агаар: \_\_\_\_\_ Газрын гадаргын байдал: \_\_\_\_\_

Температура: \_\_\_\_\_ Чийгшил: \_\_\_\_\_ Дулааны илтгэц: \_\_\_\_\_

Салхины хэм: \_\_\_\_\_ Салхины дундаж хурд: \_\_\_\_\_

**Барьсан хурганы талаарх мэдээлэл**

Бид 2007 оны IV сарын 20-ноос 24-ний хооронд Увс аймгийн Бөхмөрөн сумын Мандахын аараг, Сагил сумын Цагаан гол гэсэн хоёр газраас нийт 6 аргалийн хурга барьж, хүзүүвч зүүж тавилаа.

**Хүснэгт 1. Барьсан хурганы талаарх мэдээлэл**

Үзүүлэлт	1	2	3	4	5	6
<b>Барьсан газрын нэр</b>	Мандахын аараг Цахир ам	Мандахын аараг Улаан манхан	Мандахын аараг Хөдөөгийн уушиг	Цагаан гол Хөх даваа	Цагаан гол Хэрц	Цагаан гол Ногоон хараачийн Хөшөөт
<b>Барьсан огноо</b>	04/21/07	04/21/07	04/22/07	04/21/07	04/24/07	04/24/07
<b>Барьсан цаг</b>	10:40	13:06	17:23	15:10	12:03	15:01
<b>Тавьсан цаг</b>	10:53	13:16	17:35	15:21	12:13	15:07
<b>Барьсан нийт хугацаа</b>	0:13	0:10	0:12	0:11	0:10	0:06
<b>Хүйс</b>	Эр	Эм	Эр	Эр	Эр	Эм
<b>Нас</b>	3-4 цаг	1-2 хонсон	2-3 хонсон	1 хонсон	5-6 цаг	2-3 хонсон
<b>Биеийн жин</b>	13,14лб	14,1лб	12,15 ?	5,12кл	6,13кл	5,76кл
<b>Хурганы нэр</b>	Энхээ	Загдаа	Дэмчиг	Шумахер	Нэмхээ	Мөнхөө
<b>Хүзүүвчний дугаар</b>	164,511	164,166	164,092	164,415	164,041	164,302
<b>Байршил (GPS)</b>	49,84170 90,60522	49,87528 90,61514	49,80257 90,64058	50,19914 90,71399	50,17883 90,59975	50,18631 90,63953
<b>Өндөр</b>	2145	2091	1867	1819	2229	1892
<b>Чих</b>	7,9	6,7	8	7,8	7,5	7
<b>Сүүл</b>	5	4,5	4	5	4,5	3,8
<b>Урд шилбэний урт</b>	21	19,5	19	19,9	22,2	21
<b>Хойд шилбэний урт</b>	33	22	24	25	26,3	24
<b>Сэрвээний өндөр</b>	46	45,8	?	51,5	53,4	45
<b>Цээжний тойрог</b>	46	45,5	53	38	44	49
<b>Биеийн нийт урт</b>	73	70,8	71	64,5	67	71
<b>Хүзүүний тойрог</b>	21	19,5	?	19	21,8	19
<b>Турууны урт/өргөн</b>	3,6x1,8	4,1x2	4,4x3	3,2x1,8	4x2	4,2x3,7
<b>Биеийн температур</b>	38,8	39,2	37,9	38,3	38,9	28,5
<b>Амьсгалын тоо</b>	?	?	?	78	66	?
<b>Цаг агаар</b>	Хүйтэн салхтай	Хүйтэн салхтай	Салхтай, нартай	Үүлэрхэг салхтай	Нартай дулаан	Нартай дулаан
<b>Газрын гадаргын байдал</b>	Завчим энгэр, хад асагтай	Хадтай толгодын өвөр энгэр	Налуу газар, хадны ёроолд	Хад асагтай энгэр	Хад асагтай хясаан дотор	Толгодын ар бэл налуу хадны ёроол
<b>Барьсан</b>	Мандах	Мандах	Мандах	Цогтжаргал	Цогтжаргал	Ганболд

**Оролцогчид:** Энэ удаагийн хээрийн судалгаанд нийт найман хүн ажилласан бөгөөд тэдгээрийн нэрсийг дор жагсаав. Жагсаалтын эхний 5 хүн Мандахын аарагт, сүүлийн 3 хүн Цагаан голд ажилласан. Ажлын эхний үе, төгсгөлийн үед хоёр баг хамтран ажиллаж, хурга барих төгсгөлийн ажиллагааг хамтын хүчээр зохион байгуулсан болно.

1. Б.Ганболд – Ирвэс-1 багийн ахлагч
2. Р.Мандах – Ирвэс-1 багийн гишүүн, Бөхмөрөн сумын II багийн иргэн
3. Т.Загдсүрэн - Бөхмөрөн сумын III багийн иргэн
4. Л.Нэмэхбаяр - Бөхмөрөн сумын III багийн иргэн
5. Б.Энхээ – Улаангом сумын иргэн (тогоочоор ажилласан)
6. О.Мөнхтогтох – ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн салбарын байгаль хамгааллын ажилтан
7. Г.Цогтжаргал – Аргаль төвийн ажилтан, судлаач
8. Ши.Гантулга - ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн салбарын жолооч

### **Аргаль хонины тоо толгойн талаар**

Мандахын аараг, Цагаан гол гэсэн хоёр газарт байгаа аргаль хонины тоо толгойн талаар өмнөх жилийн мэдээлэл бидэнд бий. Гэхдээ энэ тайланд аргаль хонины хурга барих үеийн ажиглалтын дүнг нэгтгэн оруулав. Ажиглалт 2007 оны 4-р сарын 10-ны өдрөөс 24-ний өдрийг дуустал 15 хоногийн хугацаанд явагдсан болно.

### **Мандахын аараг**

Мандахын аарагт нийт бие бүрэлдэхүүн 4-р сарын 16, 17-ний өдөр хоёр хэсэг болж хамрах ёстой нийт нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарч аргаль хонины тооллого бүртгэл хийлээ. Энэ хугацаанаас өмнө Бөхмөрөн сумын байгаль хамгаалагч Р.Мандах ажиглалт, тооллого хийсэн болно. 2007 оны 4 дүгээр сарын 16,17-ноос хойших хугацаанд дээрх тоонд үндэслэн төрөх аргаль хонийг нарийвчлан ажиглах, тэндний байршил, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих зэргээр ажилласан болно. Ингээд дээр дурьдсан хоёр өдрийн аргаль хонины тоон мэдээг дор нэгтгэв. Үүнд:

### **А. Хомийн тоо толгой**

1. Сэвшиг ууланд 12 эм (бие гүйцсэн 6, төлөг 6)
2. Улаан манханд 21 эм. Үүний 15 нь (бие гүйцсэн 12, төлөг 3) тус уулын ар, өвөрт 6 (бие гүйцсэн -3, төлөг 3) байлаа.
3. Цахир 8 эм (сүргийн бүтэц тодорхой бус). Өмнөх өдөр нь Цахир аманд 17 байсан (4+7+6 гэсэн тоо тойгоор) бөгөөд дараагийн өдөр нь эдгээрийн 9 нь Өмнө живэртэд очсон гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хоёр өдрийн тоон дүн барьж байгаа болно.
4. Өмнө живэрт 9 эм (бие гүйцсэн, хээлтэй -5, төлөг -4)
5. Бээлийн өвөр 4 эм (бие гүйцсэн бодгаль). Урьд өдөр нь энд байгаагүй бөгөөд эдгээр нь хойд хэсгээс орж ирсэн гэж үзсэн.
6. Ортуутын орой 9 эм (бие гүйцсэн, хээлтэй -5, төлөг -4)
7. Арагт 4 эм (тодорхой бус)

Ингээд хоёр өдрийн тооллогын нэгдсэн дүнгээр Мандахын аараг орчимд төрөхөөр салж сүрэглэсэн эм бодгалийн тоо 67 байлаа. Зарим сүргийн дотор байгаа төлөгний тоон нийлбэр, бие гүйцсэн, хээлтэй аргалийг тоолсон байдлаар үзэхэд 2007 оны хавар Мандахын аарагт 40-43 толгой аргаль хонь төрнө гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, төрөхөөр сүрэглэсэн нийт хомийн (67) гурваны нэг нь төрөхгүй гэж үзэж байгаа болно.

#### **Б. Сувай бодгалийн сүргийн тоо**

2007 оны 4 дүгээр сарын 16, 17-ний өдрийн болон түүнээс хойших тооллогоор Ботоон хүүш гэдэг газарт буюу Мандахын аараг орчмын хамгийн өндөрлөг, армаг тармаг цастай газарт сувай бодгалийн сүрэг 23 толгойгоос бүрдэж байлаа.

#### **В. Угалзын тоо толгой**

2007 оны 4 дүгээр сарын 16, 17-ний өдрийн ажиглалтаар сувай сүргийн хажууд 3 угалз байлаа. Байгаль хмагаалагч Р.Мандахын мэдээлснээр 20 орчим угалз орж ирсэн байсан бөгөөд эдгээр нь Цагаан гол руу буцсан гэсэн дүгнэлтийг бид хийлээ.

#### **Цагаан гол**

Цагаан голд энэ оны 4 дүгээр сарын 18, 19-ний өдрийн ажиглалтаар нийт аргаль хонины байршил, тоо толгой, сүргийн бүтцийн талаарх мэдээг нэгтгэсэн болно. Үүнээс хойших хугацаанд төрөх бодгалийг ажиглах, барих ажил хийсэн болно. Цагаан гол орчмын аргаль хонины тоо толгойг дор нэгтгэв. Үүнд:

#### **А. Хомийн тоо толгой**

1. Хөх даваа орчимд 2 эм
2. Хар аманд 19 эм
3. Уёны эхэнд 3 эм
4. Цагаан хөтөлд 2 эм (19-нд анхны хургатай хомийг энд үзсэн бөгөөд 20-нд нөгөө нь хургалсан болно).

Нийтдээ 26 толгой эм бодгаль тоологдсон болно. Эдгээрээс 16-17 толгой төллөнө гэж тооцож байна. 4-р сарын 19-нөөс 24-ний хоорондын 6 өдрийн ажиглалтаар нийтдээ 7 толгой хомь төрсөн болно. Энэ хугацаа нь хомь ид төллөж эхэлсэн хугацаа юм.

#### **Б. Сувай бодгалийн сүргийн тоо**

Өнгөрсөн жил сувай бодгальтай сүрэг 20 гаруй толгойтой байсан бөгөөд энэ жил сувайчуудын сүргийг олж хараагүй болно. Өөрөөр хэлбэл, Бураат уулын орой, Харгайтын эх зэргээр хээрийн судалгаа хийгдээгүй болно.

#### **В. Угалзын тоо толгой**


Бидний ажигласнаар Бага бураатад 11, Харгайтын дунд хамар (Харгайтын амны урд талын уулны хар модон төгөлийн ойролцоо) 8, нийтдээ 19 толгой угалз тоологдлоо.

Үүнээс гадна Хар аманд 5 толгой буга үзлээ. Нэг нь эвэртэй бусад нь эвэргүй байсан. Холоос ажигласан бөгөөд тэдгээрийн гадаад төрхөөс үзвэл бүгдээрээ буга бололтой (согоогүй).

### Аргаль хонины хурга барих хугацааны тухай

Өнгөрсөн жил дбууу 2006 онд 4-р сарын 17-нд Цагаан голд буудалласан болно. Ингэхэд хомь төллөсөн байсан. Иймээс өнгөрсөн жил өнөтэй сайхан өвөл болсон тул эрт төллөнө гэж үзээд 4-р сарын 10-нд Мандахын аарагт буудаллаж ажиглалт хийж эхэлсэн. Гэтэл энэ жил анхны хургыг Мандахын аараг, Цагаан голд 4-р сарын 19-ний өдөр нэгэн зэрэг харсан болно. Иймээс юуны өмнө Мандахын аараг, Цагаан голд хомь зэрэг төллөдөг байна. Манай хашир малчдаас авсан аман мэдээгээр өвөл өнтөй ороход малын төллөх хугацаа 5 хоногоор хойшилдог юм байна. Иймээс цаашид Мандахын аараг, Цагаан голд аргаль хонины хурга барихын тулд 4-р сарын 15-нд газар дээрээ байрлахад болох юм байна гэж үзлээ. Нөгөө талаар Мандахын аараг, Цагаан гол зэрэг урьд өмнө нь ажиллаад газар нутгаа мэддэг болсон тохиолдолд 4-р сарын 15-нд гэрээ барьж буудаллаад анхны хурга гарах хүртэл ажиглалт хийж болох юм. Ажиглалт эхлэхэд Увс, Ховд аймагт хурга барих баг бэлэн байдалд байж байгаад анхны хурга гарсан мэдээлэл авснаас нэг хоногийн дараа очоод барилт хийхэд хоног хугацаа хэмнэх, хөрөнгө мөнгө бага зарах боломжтой гэж үзэж байна. Бидний тооцоолсноор анхны хурга гарснаас хойш цөөхөн хургыг 7 хоногийн дотор барих боломжтой гэж үзэж байна.

Газрын зураг 1. Аргаль хонины хурга барьсан газар нутгийн байршил



## ДҮГНЭЛТ САНАЛ

1. 2006 онд бид өөрсдийн дотоод нөөц бололцоогоор аргаль хонины хурга барих талаар дадлага туршлага хийсэн. 2007 онд урьд нь хуримтлуулсан туршлага дээрээ тулгуурлан хурга барьж хүзүүвч зүүх ажлыг өөрсдийн хүчээр хийлээ. Улаанбаатараас Г.Цогтжаргалыг томилолтоор ажиллуулсан. Энэ үндсэн дээр аргаль хонины хурга барихыг ажлыг бид өөрсдөө хийх чадавхитай болсон гэж дүгнэлээ. Иймээс цаашид хавар хурга барих ажилд гадаадын мэргэжилтэн огт хэрэггүй. Хурга барилт, ажиглалт судалгааны ажлын үр дүнг шинжлэх ухааны эргэлтэд оруулах үүднээс Улаанбаатараас нэгийн зэрэг мэргэжилтэн оролцуулж болох юм. Энэ нь тухай жилийн ажлын зорилго, гарах үр дүн, хэд хичнээн хурга барих зэргээс хамаарч болох юм.
2. Аргаль хонины хил дамнасан шилжилт хөдөлгөөнийг судлахын тулд сансрын дохиолол бүхий хүзүүвч зүүх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Энэ нь санхүүгийн байдалтай холбоотой нь ойлгомжтой боловч ОХУ-тай хамтран хийх тохиолдолд хэрэгжүүлэх боломжтой болов уу. Бидний хяналтаар Мандахын аарагт хүзүүвч зүүсэн “Миша” энэ оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар ОХУ-ын нутаг дэвсгэрт дохиолол өгч байлаа.
3. Холбооны тухайд энэ жил Ш.Гантулгын машины хэт богино долгионы станцийг нэг гар станцтай авч явж ажиллуулсан болно. Энэ нь машины аккумулятор болон орой мотор асаах үед цэнэглэдэг тул зай зарцуулахгүй, холын зайд барьдаг, найдвартай ажиллагаатай зэрэг давуу талтай байлаа. Иймээс дараа жилээс хурга барих тохиолдолд машины суурин станц нэгийг аль нэг өндөрлөг дээр аккумуляторын хамт байрлуулаад (ингэж байрлуулахгүйгээр станцитай машинаа төв хэсэгт ажиллуулсан ч болно) оролцогчдод гар станц тарааж холбоо барих нь илүү найдвартай гэж үзлээ.
4. Мандахын аараг, Цагаан голд аргаль хонины хурга барихын тулд 4 дүгээр сарын 15-нд газар дээрээ байрлахад болох юм байна гэж үзлээ. Нөгөө талаар Мандахын аараг, Цагаан гол зэрэг урьд өмнө нь ажиллаад газар нутгаа мэддэг газарт 4-р сарын 15-нд гэрээ барьж буудаллаад анхны хурга гарах хүртэл 1-2 хүнээр ажиглалт хийлгэж байгаад анхны хурга гарсан мэдээлэл авснаас нэг хоногийн дараа Увс, Ховд аймагт хурга барих баг бэлэн байдалд байж байгаад очоод барилт хийхэд хоног хугацаа хэмнэх, хөрөнгө мөнгө бага зарах боломжтой гэж үзэж байна. Мөн хурга барьж буй хилийн застав, постын хамт олонд хурга барих арга барлийг зааж сургаж туслалцаа хавах боломжтойгоос гадна мөнгө санхүүгийн хэмнэлттэй байж болох талтай юм. Хурга барих ажилд хилийн албан хаагчдийг татан оролцуулсанаар хилийн дагуух ан амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл авах, ан амьтдыг хаарлан хамгаалах талийн мэдлэгтэй болох тал бий.
5. Бидний тооцоолсноор анхны хурга гарснаас хойш цөөхөн хургыг 7 хоногийн дотор барих боломжтой гэж үзэж байна.
6. Хурга барьсан үед хажууд нь олон хүн байлгахгүй байх. Мөн хурга барьхад шаардлагтай багаж хэрэгсэлийг сайтар бэлдэх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд: Хурганд зүүх өнгө өнгийн дугаар бүхий ээмэг бэлдэх (энэ нь хурганд зүүж байгаа хүзүүвч нь 1-2 жилийн хугацаатай байдаг болхоор хүзүүвчны хугацаа дуусаад унсан дохиолдолд тухайн хургыг танихгүй, цаашид мэдээлэл авж чадахгүй болдог, хэрэв өнгө дугаар бүхий ээмэг зүүсэн дохиолдолд хүзүүвч унсанч ээмгээр таньж мэдээлэл авах бүрэн боломжтой), цаг агаарын жижиг багж (Kestrel 900), судалгаанд оролцож байгаа хүмүүст хээр юм бичихэд тохиромжтой гар хавтас зэрэг баэгж хэрэгсэл хэрэгтэй.

